



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/23

Пионер толгой

“Өрхийн хөгжлийг дэмжих цогц арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, “Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2.1.6, Баянхонгор аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.6, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.3.6.3 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2023 оны А/94 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Өрхийн хөгжлийг дэмжих цогц арга хэмжээ”-г сумын хэмжээнд хэрэгжүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч	Р.Гантулга	Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүд	Д.Буянаа	Насан туршийн боловсролын нэгжийн менежер
	Б.Цэеэ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний мэргэжилтэн
	П.Цэрэндолгор	Сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Ц.Орхонтуул	Сургуулийн нийгмийн ажилтан
	Э.Цэрэнханд	Цэцэрлэгийн эрхлэгч
	Г.Сүхбаатар	Эрүүл мэндийн төвийн дарга
	Н.Цагаанлянх	Нийгмийн эрүүл мэндийн ажилтан
М.Бат-Эрдэнэ	Байгаль хамгаалагч	
Б.Лусаншийрэв	Цэнгэл 1 дүгээр багийн Засаг дарга	

642201217

Д.Мөнхчулуун	Давааны ам 2 дугаар багийн Засаг дарга
Д.Болд-Аюуш	Буга 3 дугаар багийн Засаг дарга
Б.Баттулга	Хөвийн ам 4 дүгээр багийн Засаг дарга
Ч.Батцэцэг	Пионер толгой 5 дугаар багийн Засаг дарга
Л.Дуламдорж	Хэсгийн төлөөлөгч
М.Эрдэнэдалай	Эрчим хүчний байцаагч
Нарийн бичгийн дарга	Б.Мөнхдалай Сумын Нийгмийн бодлогын мэргэжилтэн

2.“Өрхийн хөгжлийн цогц арга хэмжээ”-нд хамрагдах өрхүүдийг сонгож, нөхцөл байдлын үнэлгээг хийн, өрхийн хөгжлийн төлөвлөгөөг өрх бүрээр боловсруулж, салбар хоорондын ажлын уялдаа холбоог хангаж, хамтран ажиллахыг ажлын хэсэг (Р.Гантулга)-т үүрэг болгосугай.

3.Өрхийн хөгжлийг дэмжих арга хэмжээний үр дүнг тооцож, үйл ажиллагааны тайланг хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг Нийгмийн бодлогын мэргэжилтэн (Б.Мөнхдалай), Насан туршийн боловсролын нэгжийн менежер (Д.Буянаа) нарт хариуцуулсугай.

ДАРГА  Б.ГАНТУЛГА

